



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/633

Булган сум

**Бог малын мялзан өвчнөөс урьдчилан
сэргийлэх нэгдсэн дархлаажуулалтыг
зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5, 9.6, 9.7, 9.8 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.2, 28.4 дэх хэсэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны А/315 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эрсдэл бүхий сумдын зорилтот мал сүрэгт 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 25 хоногийн хугацаанд дархлаажуулалтын ажлыг шуурхай зохион байгуулсугай.

2. Дээрх ажлын төлөвлөгөө, хуваарийг хавсралтаар баталж, шаардагдах вакциныг сумдад хуваарилан, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн)-т даалгасугай.

3. Сум орон нутагтаа дархлаажуулалтын арга хэмжээг тогтоосон хугацаанд чанартай зохион байгуулж, хүн хүч, машин техник, шатахуун, шаардагдах хөрөнгөөр хангаж ажиллахыг холбогдох сумдын Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6324010877

Аймгийн Засаг даргын 2024 оны
 09 дүгээр сарын 27-ний өдрийн 1633
 дугаар захирамжийн хавсралт



БОГ МАЛЫН МЯЛЗАН ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ВАКЦИНЫ ХУВААРЬ

№	Сумын нэр	Хамрагдах малын тоо						Вакцин		Шингэлэгч /ш/
		Хонь	Хурга	Ишиг	Бүгд	Тун	Ширхэг			
1	Баян-Агт	129,862	37,157	17,690	184,709	184,600	1,846		923	
2	Баяннуур	19,810	1,500	900	22,210	22,200	222		111	
3	Бугат	23,002	14,765	9,870	47,637	47,600	476		238	
4	Булган	21,000	7,711	5,737	34,448	34,400	344		172	
5	Бүрэгхангай	160,000	23,000	10,200	193,200	193,200	1,932		966	
6	Гурванбулаг	152,992	35,862	14,072	202,926	203,000	2,030		1,015	
7	Дашинчилэн	79,864	17,196	9,138	106,198	106,200	1,062		531	
8	Могод	198,156	25,601	3,843	227,600	227,600	2,276		1,138	
9	Рашаант	50,600	22,000	6,500	79,100	79,200	792		396	
10	Орхон	145,033	54,358	34,732	234,123	234,200	2,342		1,171	
11	Сайхан	182,830	21,579	7,064	211,473	211,400	2,114		1,057	
12	Сэлэнгэ	34,434	17,000	9,000	60,434	60,400	604		302	
13	Тэшиг	31,833	14,185	10,181	56,199	56,200	562		281	
14	Хангал	34,805	10,951	8,017	53,773	53,800	538		269	
15	Хишиг-өндөр	138,635	50,626	22,927	212,188	212,200	2,122		1,061	
16	Хутаг-өндөр	127,434	23,192	12,756	163,382	163,400	1,634		817	
	Дүн	1,530,290	376,683	182,627	2,089,600	2,089,600	20,896		10,448	